



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь.

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан 255,695,083.00 (хоёр зуун тавин таван сая зургаан зуун ерэн таван мянга наян гурван) төгрөгийн балансын үнэ, 117,487,976.83 (нэг зуун арван долоон сая дөрвөн зуун наян долоон мянга есөн зуун далан зургаан төгрөг наян гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газар (Ерөнхийлөгчийн Тамгын газрын ажлын албанд ашиглах)-т балансаас балансад шилжүүлсүгэй.

2.“Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболд нарт дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлогчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

132001324

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газар /Ерөнхийлөгчийн Тамгын газрын ажлын албанд ашиглах/-т балансаас балансад шилжүүлэх автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ландкрузер-200, 01-38 УБҮ, арал № JTMHV05.1704257123	2018/ 2018	255,695,083.00	117,487,976.83	138,207,106.17
	Нийт дүн		255,695,083.00 (хоёр зуун тавин таван сая зургаан зуун ерэн таван мянга наян гурван)	117,487,976.83 (нэг зуун арван долоон сая дөрвөн зуун наян долоон мянга есөн зуун далан зургаан төгрөг наян гурван мөнгө)	138,207,106.17 (нэг зуун гучин найман сая хоёр зуун долоон мянга нэг зуун зургаан төгрөг арван долоон мөнгө)